DFC U.S. International Development Finance Corporation

АНУ-ын Олон улсын хөгжлийг санхүүжүүлэх корпораци

Хөгжилд хөрөнгө оруулна

ДЧХХОК-ийн Монгол улс дахь хөрөнгө оруулалт

Төслийн нэр	АНУ-ын спонсор	ДЧХХХОК-ийн зээлийн дүн	Тайлбар
Гоёл кашмир	Вивек Ранжан	3.25 сая ам.доллар	Эмэгтэй хүний үүсгэн байгуулсан, түүнээр удирдуулсан ноолуураар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бизнесийг өргөтгөх
Щульц Глобал Монголиа Зээл олгогч	Щульц Глобал Инвестментс	9.99 сая ам.доллар	ЖДҮ-үүдэд 500,000 - 3 сая ам.долларын зээл олгодог байгууллага
Хас Банк	Каргилл Санхүүгийн Үйлчилгээ	49 сая ам.доллар	Эмэгтэй бизнес эрхлэгчдэд боломж олгох зээл (ЭБЭБОЗ) - Монгол Улсад эмэгтэй өмчлөгчтэй ЖДҮ-т олгох зээл
Улаанбаатар Олон улсын сургууль	Саналын эрхтэй удирдах зөвлөлийн АНУ-ын иргэн 6 гишүүн	20 сая ам.доллар	Олон улсад итгэмжлэгдсэн, ашгийн бус, 12 жилийн сургуулийн өргөтгөл
WBC Голомт Банк	Санхүүгийн Үйлчилгээ Сайн дурын корпус	14.6 сая ам.доллар	Банкны ХАА-н бизнест төвлөрсөн ЖДҮ-ийн зээлийг өргөжүүлэх
KFC/Pizza Hut	Таван Богд Фүүдс	7.25 сая ам.доллар	Yum! Asia Master франчайзингийн гэрээгээр Монгол Улсад Кэй ЭФ Си, Пицца Хатын бизнес байгуулсан
Говь Финанс ББСБ	Ральф Паркс	2 сая ам.доллар	Бичил бизнес болон ЖДҮ-ийн санхүүжилтийг өргөтгөх
	ДЧХХХОК-ийн одоогийн хөрөнгө оруулалт	106.1 сая ам.доллар	

BUILD Хууль

2018 оны 10-р сард батлагдсан BUILD Хууль буюу Хөгжилд хүргэх хөрөнгө оруулалтын ашиглалтыг сайжруулах тухай хууль нь Далайн чанад дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын корпораци (ДЧХХХОК) болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Хөгжлийн зээлийн газрыг нэгтгэн орчин үеийн хөгжлийн санхүүжүүжилтийн институци болгосноор:

- **Хөрөнгө оруулалтын дээд хязгаар нь өндөр**
- **Шинэ арга хэрэгсэл**
- **Бага орлоготой улсуудад илүү анхаарна.**
- **Агентлаг хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлнэ.**

Бидний тухай

ХСК нь АНУ-ын Засгийн газрын хөгжлийн санхүүгийн байгууллагын хувьд **хөгжиж буй улс орон, зах зээлд** төсөл хэрэгжүүлж буй хувийн хэвшлийн компаниудын төсөлд санхүүжилт, эрсдэл бууруулах санхүүгийн хэрэгсэл олгодог.

Манай үйлчилгээ

DFC U.S. International Development Finance Corporation

Өр санхүүжүүлэх

Хувийн салбарын ашгийн төлөөх төсөлд 500 сая ам.доллар хүртэл хариу нэхэмжлэл хязгаарлагдмал урт хугацааны зээл, баталгааг 20 жил хүртэл хугацаатай олгоно.

Улс төрийн эрсдлийн даатгал

Валют үл хөрвөх, засгийн газрын оролцоо, улс төрийн хүчирхийлэл гэх зэрэг эрсдлээс 500 сая ам.доллар хүртэл хамгаалалт

Хөрөнгө оруулалтын сан

Хөгжиж буй зах зээлийн хувийн хувьцааны хөрөнгө оруулалтын санд зээл олгож хөрөнгө оруулах

ТЭЗҮ

ХСК-ийн дэмжиж болох төсөлд техникийн туслалцаа үзүүлэх

Техник туслалцаа

ХСК-ийн дэмжиж болох төсөл хэрэгжих боломжтой эсэх, тогтвортой байдал, үр нөлөөний үнэлгээ

Манай ажлын хүрээ

Төслийн болзол

Манай төсөл **хувийн хэвшлийг** үр дүнтэй байдлаар оролцуулах уу??

Манай төсөл **нийгэм, хүрээлэн буй орчны өндөр стандарт** баримтлах уу?

Манай төсөл **АНУ дахь ажлын байруудад** сөргөөр нөлөөлөх үү?

Сонирхож буй улсад ХСК нээлттэй юу?

Манай төсөл **хориотой салбар**т хамаарагдах уу?

Төслийн мөчлөг

Эх үүсвэр олох	Урьчилсан шалгаруулалт	Бүртгэл	Магадалгаа	Зөвшөөрөл	Төслийн хаалт	Мониторинг
ХСК-ийн ажилтантай ярилцах	Төсөл нь болзол хангасан эсэх, ХСК-ийн зорилготой нийцэх эсэх, бусад төсөлтэй харьцуулахад ХСК-ийн нөөц бололцоог хир их шаардах зэрэг	www.dfc.gov сайтад бүртгүүлэх	Харилцагчийн зээл, гарах үр нөлөө, хууль биелүүлж байгаа байдал, төлөв байдлын эрсдэл	Хороо болон удирдлагаар шалгуулах	Гэрээний дараах хэлэлцээр ба гэрээний урьдчилсан нөхцлүүдийг биелүүлж чадах эсэх	Санхүүгийн эрүүл байдал, бодлого баримталж байгаа эсэх

Манай ажлын үр нөлөө

10 сая
Бичил санхүүжилтийн зээлдэгч

3.5 ГВтын
Эрчим хүч

200,000
Орон сууцны зээл

7 сая
Эмчлүүлэгч жил бүр

150 тэрбум
Литр ус жил бүр

Дэлхий даяарх эмэгтэйчүүдийг чадавхижуулах

ХСК-ийн 2X Эмэгтэйчүүдэд зориулсан санаачлага эмэгтэйчүүдийн өмчийн, эмэгтэйчүүдийн удирдсан эсвэл тэдний дэмжлэгийг авсан аж ахуйн нэгж, сангуудад 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулж чадсан.

Африкийг дэлхийтэй холбох

ХСК нь Африктай холбогдох санаачилгаараа Африкийн **МХХТ (мэдээлэл, харилцаа холбооны технологи), нэмүү өртгийн хэлхээ, амин чухал дэд бүтцэд** 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.

Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүсийн төлөө

ХСК-ийн Энэтхэг-Номхон далайн бүсийн дижитал эдийн засаг, дэд бүтэц, эрчим хүчний салбарт оруулж буй хөрөнгө оруулалт нь төрөөс удирдсан тогтворгүй хөрөнгө оруулалтын загварыг орлох тогтвортой хувилбарыг хөгжүүлж байна.



Холбоо барих, нэмэлт мэдээлэл

Холбоо барих

Нэр: Жеффри Тан
Geoffrey.Tan@opic.gov

АНУ-ын Олон улсын хөгжлийг санхүүжүүлэх корпораци (ХСК)

1100 New York Avenue, N.W
Washington, D.C. 20527 USA

Нэмэлт мэдээлэл

Нэмэлт мэдээлэл авах бол
www.dfc.gov.
сайтд зочилно уу.